



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дипломат төлөөлөгчийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/022/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1200
танай _____-ны № _____-т

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.МӨНХТҮШИГ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Дипломат төлөөлөгчийн газрын арилжааны банкны дансанд Дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоогүй, тайлант онд хамаарахгүй зардлын 2,505.0 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлэн авч, өглөгөөр бүртгэсэн;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 407.9 сая төгрөгийн авлага, 88.2 сая төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэж, тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Санхүүгийн тайланд гурваас дээш жилийн насжилттай 557.1 сая төгрөгийн авлага, 129.5 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй;
- "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж хангамж, бараа материалын зардлаас 14.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,145.8 сая төгрөг, нийт

1,160.5 сая төгрөгөөр барилга байгууламжийн сайжруулалт хийж, хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Дипломат төлөөлөгчийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,745.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 2,300.0 сая төгрөгийн их засварын ажил гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дипломат төлөөлөгчийн газрын 2024 оны төсвийн жилд зарцуулах зардлыг 157,246.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 113,017.5 сая төгрөг буюу 71.9 хувьтай байгаа нь Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт бүрэн биелэхгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Дипломат төлөөлөгчийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,847,906.0	11,991,531.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	913,297.6	3,513,045.0
33	АВЛАГА	3,127,039.2	3,513,910.4
34	УРЬДЧИЛГАА	1,260,003.5	260,125.8
35	БАРАА МАТЕРИАЛ	4,547,565.6	4,704,450.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	461,344,810.1	463,979,920.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	461,344,810.1	463,979,920.3
39100	Газар	45,966,490.4	46,095,332.2
39200	Биет хөрөнгө	384,253,555.2	386,676,609.2
39300	Биет бус хөрөнгө	31,124,764.5	31,207,978.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	471,192,716.1	475,971,452.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	619,862.6	2,895,113.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	619,862.6	2,895,113.1
41300	Өглөг	619,862.6	2,895,113.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	470,572,853.4	473,076,338.9
51	Засгийн газрын хувь оролцоо	470,572,853.4	473,076,338.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	189,945,563.1	189,945,563.1
51200	Хуримтлагдсан үр дүн	(120,440,612.2)	(122,769,374.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,200,863.6	251,200,863.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	149,867,039.0	154,699,287.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	471,192,716.1	475,971,452.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	144,891,526.8	179,514,756.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,421,445.0	12,170,596.7
120	Нийтлэг татварын бус орлого	15,421,445.0	12,170,596.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,470,081.8	167,344,159.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	159,821,847.2	185,720,988.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,821,847.2	176,896,456.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,307,100.9	131,897,726.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,218,324.9	51,130,609.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	861,887.1	1,826,744.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,459,068.5	25,320,386.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,944,978.8	3,059,433.6
2105	Нормативт зардал	18,154.3	15,099.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,894,299.6	1,737,278.0
2107	Томилолт, зочны зардал	6,536,005.5	8,035,277.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,151,593.4	17,960,627.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,222,788.8	22,812,271.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,514,746.2	44,998,730.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,824,531.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(14,930,320.4)	(6,206,231.8)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	142,950.8	502,286.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,083.9	599,701.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(14,790,453.6)	(6,303,646.9)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	145,374,185.6	178,737,900.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,082,213.9	11,393,740.6
120	Нийтлэг татварын бус орлого	12,082,213.9	11,393,740.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	133,291,971.7	167,344,159.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	141,865,180.4	164,794,057.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	141,865,180.4	164,794,057.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,350,434.2	112,885,832.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,098,837.3	50,228,187.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	859,227.2	1,715,240.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,793,867.8	25,642,683.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,977,785.6	3,016,869.7
2105	Нормативт зардал	30,307.0	29,529.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,993,111.0	1,694,623.3
2107	Томилолт, зочны зардал	6,667,491.1	8,075,332.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,427,201.1	18,500,634.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,502,606.2	3,982,730.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,514,746.2	51,908,225.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,509,005.2	13,943,842.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,518,819.0	11,220,314.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,518,819.0	11,220,314.5
2200	Дотоод эх үүсвэрээр	4,518,819.0	11,220,314.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,518,819.0)	(11,220,314.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(583,149.1)	(123,780.6)
14	Бусад эх үүсвэр	-	108,491.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	583,149.1	232,272.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,592,962.9)	2,599,747.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,506,260.6	913,297.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	913,297.6	3,513,045.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,529,312.4	-	497,529,312.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,529,312.4	-	497,529,312.4
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(12,166,005.4)	-	(12,166,005.4)
9	Тайлант үеийн үр дүн	(14,790,453.6)	-	(14,790,453.6)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,572,853.4	-	470,572,853.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,572,853.4	-	470,572,853.4
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	8,807,132.3	-	8,807,132.3
19	Тайлант үеийн үр дүн	(6,303,646.9)	-	(6,303,646.9)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	473,076,338.9	-	473,076,338.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,246,255,800.00	113,017,464,191.31	44,228,791,608.69	71.9
УРСГАЛ ЗАРДАЛ	157,246,255,800.00	113,017,464,191.31	44,228,791,608.69	71.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,840,776,000.00	112,941,846,532.31	43,898,929,467.69	72.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,100,224,100.00	49,138,518,728.44	16,961,705,371.56	74.3
Үндсэн цалин	64,968,021,300.00	49,138,518,728.44	15,829,502,571.56	75.6
Нэмэгдэл	1,132,202,800.00	-	1,132,202,800.00	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,818,999,600.00	1,715,240,756.95	103,758,843.05	94.3
Тэтгэврийн даатгал	1,818,999,600.00	1,715,240,756.95	103,758,843.05	94.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,141,904,200.00	24,805,799,440.79	7,336,104,759.21	77.2
Гэрэл, цахилгаан	2,377,544,300.00	1,428,493,554.81	949,050,745.19	60.1
Түлш, халаалт	2,618,728,200.00	1,562,872,709.54	1,055,855,490.46	59.7
Цэвэр, бохир ус	1,032,602,700.00	645,465,836.41	387,136,863.59	62.5
Байрны түрээс	26,113,029,000.00	21,168,967,340.03	4,944,061,659.97	81.1
Хангамж, бараа материалын зардал	4,464,305,500.00	2,985,123,014.52	1,479,182,485.48	66.9
Бичиг хэрэг	543,458,300.00	297,177,782.79	246,280,517.21	54.7
Тээвэр, шатахуун	1,950,517,600.00	1,387,921,138.65	562,596,461.35	71.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,406,382,100.00	866,249,157.37	540,132,942.63	61.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,047,400.00	25,988,709.33	99,058,690.67	20.8

Дипломат төлөөлөгчийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	438,900,100.00	407,786,226.38	31,113,873.62	92.9
Нормативт зардал	113,886,900.00	29,529,794.35	84,357,105.65	25.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	113,886,900.00	29,529,794.35	84,357,105.65	25.9
Эд хогшил, урсгал засварын зардал	5,299,726,000.00	2,853,397,096.38	2,446,328,903.62	53.8
Багаж, техник, хэрэгсэл	1,957,223,800.00	1,182,034,337.07	775,189,462.93	60.4
Тавилга	367,500,000.00	161,604,058.77	205,895,941.23	44.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,758,000.00	-	24,758,000.00	0.0
Урсгал засвар	2,950,244,200.00	1,509,758,700.54	1,440,485,499.46	51.2
Томилолт, зочны зардал	12,885,792,300.00	7,971,217,082.89	4,914,575,217.11	61.9
Гадаад албан томилолт	9,601,776,400.00	5,114,173,204.69	4,487,603,195.31	53.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,284,015,900.00	2,857,043,878.20	426,972,021.80	87.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,052,369,300.00	19,585,790,026.45	7,466,579,273.55	72.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,339,023,200.00	6,346,782,243.36	1,992,240,956.64	76.1
Даатгалын үйлчилгээ	17,963,717,700.00	12,933,697,060.50	5,030,020,639.50	72.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	196,966,200.00	57,673,354.69	139,292,845.31	29.3
Газрын төлбөр	49,317,900.00	10,735,783.50	38,582,116.50	21.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	503,344,300.00	236,901,584.40	266,442,715.60	47.1
Бараа үйлчилгээний бусад зардал	6,963,568,100.00	3,857,230,591.54	3,106,337,508.46	55.4
Бараа үйлчилгээний бусад зардал	528,726,700.00	95,432,341.86	433,294,358.14	18.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,434,841,400.00	3,761,798,249.68	2,673,043,150.32	58.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	405,479,800.00	75,617,659.00	329,862,141.00	18.6
Бусад урсгал шилжүүлэг	405,479,800.00	75,617,659.00	329,862,141.00	18.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	366,259,200.00	63,677,659.00	302,581,541.00	17.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,220,600.00	11,940,000.00	27,280,600.00	30.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,246,255,800.00	116,482,295,861.43	40,763,959,938.57	74.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	156,446,255,800.00	115,487,555,834.24	40,958,699,965.76	73.8
Улсын төсвөөс санхүүжих	156,446,255,800.00	115,487,555,834.24	40,958,699,965.76	73.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	800,000,000.00	994,740,027.19	(194,740,027.19)	124.3

Дипломат төлөөлөгчийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000,000.00	994,740,027.19	(194,740,027.19)	124.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	913,297,651.18	(913,297,651.18)	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,513,045,048.04	(3,513,045,048.04)	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		(865,084,273.26)	(865,084,273.26)	0.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	51	51	-	100.0
Төсвийн байгууллага	51	51	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	523	523	-	100.0
Удирдах ажилтан	50	50	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	267	267	-	100.0
Үйлчлэх ажилтан	206	206	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,343,779,960.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,389,768,760.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,339,768,760.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,089,668,675.00
210101	Үндсэн цалин	-	1,089,668,675.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	836,884,380.00
210301	Гэрэл, цахилгаан	-	11,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	8,000,000.00
210304	Байрны түрээс	-	817,384,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	46,500,000.00
210401	Бичиг хэрэг	-	11,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	24,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	11,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	76,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	24,500,000.00
210604	Урсгал засвар	-	52,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	104,115,705.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	44,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	60,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	59,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	1,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	125,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	125,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	50,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	50,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	50,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	954,011,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	954,011,200.00
222001	Тоног төхөөрөмж	-	954,011,200.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,343,779,960.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,343,779,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,343,779,960.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,848.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,001.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,847.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 4,848.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,991.0 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, ДТГ-ын арилжааны банкны дансанд үйл ажиллагааны санхүүжилттэй холбоогүй, тайлант онд хамаарахгүй зардлын санхүүжилт 2,505.0 сая төгрөгийг шилжүүлэн авч, өглөгөөр бүртгэсэн байна. Тус өглөгтэй холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон түүний ханшийн зөрүү нь байгууллагын санхүүгийн тайланд нөлөөлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төсөвт батлагдаагүй бусад эх үүсвэрийг төсвийн захирагчийн дансаар дамжуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, нийт 50 ДТГ-уудаас 38 ДТГ нь туслах үйл ажиллагааны орлого төлөвлөөгүй, 2,380.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.1-д "Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасан, төсөвт байгууллагын төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр тооцож гаргасан дараах орлогыг тооцно", 3.1.1-д "төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого", 3.2-т "Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан орлогыг энэ журмын гуравдугаар хавсралтад заасан үйл ажиллагаанаас олсон орлогын хүрээнд хамааруулж үзнэ", тус журмын гуравдугаар хавсралтаар баталсан “Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогыг урсгал дансаар хуваарилахад баримтлах үйл ажиллагааны төрөл” жагсаалтын 5-д "Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагаа", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулаагүй, туслах үйл ажиллагааны орлогыг давсан орлогоор авч зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3: Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 407.9 сая төгрөгийн авлага, 88.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүйгээс, тайлант онд үүссэн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, бүрэн барагдуулах албан шаардлага хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэхдээ хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг илгээж, ТӨБЗГ-аас зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам 4 дүгээр зүйлийн 4.2-т "Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Давсан орлогоос хөрөнгө бэлтгэхдээ ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч байх.

Илрүүлэлт 2: "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж хангамж, бараа материалын зардлаас 14.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 1,145.8 сая төгрөг, нийт 1,160.5 сая төгрөгөөр барилга байгууламжийн сайжруулалт хийж, хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант жилд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Илрүүлэлт 3: Санхүүгийн тайланд 3-аас дээш жилийн насжилттай 557.1 сая төгрөгийн авлага, 129.5 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Удаан жилийн насжилттай авлага, өглөгийн эзэн холбогдогчийг нь тодорхойлох арга хэмжээ зохион байгуулж, нийт авлага, өглөгийг 20.0 хувиар бууруулж ажиллах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Төвлөрүүлэн захирагч													
1	Дипломат төлөөлөгчийн газар	6	4,848,237.1			3	3,001,109.3	3	1,847,127.8				
	Дүн	6	4,848,237.1	-	-	3	3,001,109.3	3	1,847,127.8	-	-	-	-